

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-7
	1. “Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	3-4
	2. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	4-7

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 11 дүгээр сарын 29-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 37 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Г.Ганболд, Ц.Мөнх-Оргил;
Чөлөөтэй: Ж.Ганбаатар, Г.Занданшатар, Л.Оюун-Эрдэнэ, Х.Нямбаатар.

Нэг. “Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Мөнхбат: “Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Мөнхбат хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Мөнхбат: “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 11 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 10 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 11 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.МӨНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Мөнхбат: Ирц бүрдсэн тул 2022 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 29-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан албан ёсоор эхэлж байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хоёр асуудал хэлэлцэнэ.

“Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёрдугаарт, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

***Нэг. “Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай”
Байнгын хорооны тогтоолын төсөл***

“Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя. Та бүхэнд тараасан байгаа.

Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 29.1.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, дэд Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргын албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол явуулна гэж.

Мөн хуулийн 29.6-д нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулга, томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, тухайн албан тушаалд тавих нийтлэг болон тусгай шаардлага зэрэг мэдээллийг авах маягтын загварыг холбогдох Байнгын хороо батална гэсний дагуу Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулж Та бүхэнд тараасан байгаа.

Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай Байнгын хорооны тогтоол.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварыг нэгдүгээр хавсралтаар, Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварыг хоёрдугаар хавсралтаар, олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн Байнгын хорооны тогтоолын төсөл байна.

Хавсралтуудынхаа хамт байгаа. Асуулттай гишүүн байна уу? Алга байна. Саналтай гишүүн байна уу? Алга байна.

Одоо “Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

10-аас 8 гишүүн дэмжиж, 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Дараагийн асуудалд оръё.

***Хоёр. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс Төрийн байгуулалтын байнгын хороонд санал ирсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 28-ны 01/2276 тоот саналаар Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын зэрэг зиндаа зэрэглэлийг ТӨ-III болгох, төрийн өндрийг III болгох саналыг дэмжиж байна гэсэн ийм санал ирсэн байгаа.

Тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн зэрэг зиндаа ТӨ-III-ийн тусгай албан тушаалын “Монгол Улсын дээд шүүхийн шүүгч,” гэсний дараа “Монгол Улсын Ерөнхий прокурор” гэж нэмсүгэй.

2.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн зэрэг зиндаа ТӨ-IV-ийн тусгай албан тушаалын “, Монгол Улсын Ерөнхий прокурор” гэснийг хассугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхэлж дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт байна уу? Алга байна. М.Оюунчимэг гишүүнээр тасаллаа. М.Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая.

Энэ ТӨ-III, ТӨ-IV хоёр дээр яг онцгой ялгаа нь юундаа байгаа юм? Эрх мэдэл дээр нь эсвэл нэмэгдэж байгаа юм уу? Эсвэл цалин хөлс дээр нь нэмэгдэж байгаа юм уу? Эсвэл зүгээр тусгай албан тушаал гэдэг статусаар Ерөнхий прокурор хүн заавал орох ёстой гэдэг үндэслэлээр орж байгаа юм болов уу? Яагаад өмнө нь ордоггүй. ТӨ-III, ТӨ-IV дээр байсан юм бол. Тийм ээ. Ганцхан Ерөнхий прокурор ийм байсан юм болов уу?

Одоо энэ өөрчлөгдсөнөөр жишээ нь Ерөнхий прокурорын үүрэг эрх дээр ямар өөрчлөлт гарах вэ? Энэ дээр нэг асуулт асууя.

Ж.Мөнхбат: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулья.

Энэ тогтоол батлагдсанаар цалин болон эрх үүрэг дээр ямар нэгэн өөрчлөлт орохгүй. Зөвхөн төрийн ёслолын эрэмбэ дараа, зэрэг дэв, баяр ёслолоор суух суудал. Тийм ээ. Энэ дээр л өөрчлөлт орж байгаа.

Прокурорын байгууллага нь Монгол Улсын Үндсэн хуулиар эрх зүйн үндэс нь тодорхойлогдсон. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагын хувьд Монгол Улсын Ерөнхий прокурорын зэрэг зиндаа, зэрэглэлийг ТӨ-III болгон өөрчлөх асуудлаар Төрийн албаны зөвлөлөөс санал ирсэн.

Өмнө нь бол ТӨ-III дээр байсан нэг нь. ТӨ-IV болгоод энэ дээр одоо бас төрийн ёслолын л зэрэг дэвийн л асуудал байгаа. Өөр ямар нэгэн асуудал байхгүй.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Саналтай гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн. Д.Тогтохсүрэн гишүүн горимын санал.

Д.Тогтохсүрэн: Энэ бол тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байгаа юм.

Энэ бол зохион байгуулалтын шинжтэй л асуудал болохоос биш эрх зүйн хэм хэмжээ тогтоож байгаа хууль эрх зүйн томоохон үр дагавартай асуудал биш.

Тийм учраас үүнийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын саналыг гаргаж байна. Байнгын хорооны гишүүд Та бүгд дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Ж.Мөнхбат: Энэ Төрийн албаны тухай хуулийн 17.1 дээр төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилхан төрийн албан тушаалтан зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно гэж заасан байгаа.

Ингээд Д.Тогтохсүрэн гишүүний гаргасан горимын саналаар анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэдэг горимын саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

7 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

7 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар санал дэмжигдлээ. С.Амарсайхан гишүүнийг дэмжсэн. Техникийн саатал гарсан байна. Протокол тэмдэглээ.

“Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны нэгдсэн чуулганд би танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

Бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД